



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 23 өдөр

Дугаар

4/224

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, байгууллагын албан хаагчдын 2022 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан, албан хаагчдын санал болон холбогдох хууль тогтоомж шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам, Шилдэг хэлтэс шалгаруулах журмыг шинэчлэн, батлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн Л.Баярсайхан (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга) ахлагч:

Гишүүд:

Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Х.Мөнхсаруул (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ж.Уянга (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Н.Сүхбаатар (Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Даариймаа (Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)

Б.Энхмандал (Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Г.Жавзмаа (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

2. Хөдөлмөрийн дотоод журам, Шилдэг хэлтэс шалгаруулах журмыг 2022 оны 10 дугаар сарын 20-ны дотод боловсруулан батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150541